



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/376

Арвайхээр

Г Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3. "а", Засгийн газрын 2021 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээ"-ний тухай 221 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн болон төв суурингийн 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, шалгах, хүлээн авах ажлын хэсгийг нэгдүгээр, хөдөө аж ахуйн болон төв суурингийн 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээг хоёрдугаар, аймаг, сумдын аюулгүйн нөөцөд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн хэмжээг гуравдугаар, аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд, сумдаас байгалын хадлан бэлтгэх талбайн хэмжээг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухай бүрт нь шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан), Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа (Д.Одонбаяр) нарт үүрэг болгосугай.

3.Хөдөө аж ахуйн болон төв суурингийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн ажиллахыг Сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Бат-Өлзий, Уянга, Зүүнбаян-Улаан, Хархорин, Хужирт зэрэг сумдаас аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах байгалын хадлангийн зориулалтаар ашиглах 50 га-аас доошгүй талбайг гаргахыг дээрх сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг 2021 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100803



Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 137 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт

**ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ, ЗОХИОН
БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)

А. Төв суурингийн өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг:
Нарийн бичгийн дарга: Ч.Гүнсэнхорол (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд: Ц.Идэрсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Одонбаяр (Аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газрын дарга)

Д.Шивааннүрдэв (Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга)

С. Дуламсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Д.Лхам-Оролмаа ("ӨВ-АЗЗА" ТӨХКомпанийн захирал)

Б. Оюунчимэг (Ус, цаг уур орчны шинжилгээний албаны дарга)
Сумдын Засаг дарга нар

Б. Хөдөө аж ахуйн өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг:
Нарийн бичгийн дарга: С. Цэдэнбалжир (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд: Д.Ц.Идэрсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Нямдаваа (Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга)

Д.Одонбаяр (Аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газрын дарга)

Д.Шивааннүрдэв (Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга)

С. Дуламсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Д.Лхам-Оролмаа ("ӨВ-АЗЗА" ТӨХКомпанийн захирал)

Б. Оюунчимэг (Ус, цаг уур орчны шинжилгээний албаны дарга)
Сумдын Засаг дарга нар

Аймгийн Засаг даргын 2021 оны 02...
дугаар сарын 02.-ны өдрийн А/376 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт



ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨВ СУУРИНГИЙН 2021-2022 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

Нэг. Хөдөө аж ахуй болон төв суурингийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах талаар дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох газар, хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгож байна.

1.1. Аймгийн хэмжээнд 2021-2022 онд өвөлжих болон хэрэгцээлэх малыг малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тулгуурлан аймаг, сумын хэмжээнд тоог нэгтгэн боломжит хэмжээгээр эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, бүх хэлбэрээр дэмжиж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир), Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн)-д;

1.2.Отрын бүс нутгийн ашиглалтын хуваарь гаргах, нөхцөл, үйлчилгээг сайжруулах, оторлох мал сүргийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, угаалга, тарилга, туулгалтад хамруулах, тууврын замд хяналт тавихыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжирт), Мал эмнэлгийн газрын дарга (А.Нямдаваа),-д;

1.3.Цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурлан өвөл, хаврын улирлын бэлчээрийн даацыг бодитой тогтооход анхаарч ажиллах, цаг уурын, орчны аюултай, гамшигт үзэгдлийн талаарх урьдчилан сэргийлэх мэдээг иргэд, малчдад түргэн шуурхай дамжуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Ус, цаг уур орчны шинжилгээний албаны дарга (Б.Оюунчимэг)-т

1.4.Малчин өрхийн жирэмсэн эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 0-5 насны хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө гаргах, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед хадлан бэлтгэл ургац хураалтын ажилд оролцож байгаа аж ахуйн нэгж, иргэдэд урьдчилан сэргийлэх дэглэмийг мөрдүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннүрдэв)-т;

1.5.Бэлчээрийн ургамлын ургалтын байдал удааширч, мал бэлчээрлэх нөхцөл хүндэрсэн аймаг, орон нутагт гангийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг зохион байгуулж холбогдох арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлэхийг Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа (Д.Одонбаяр), Ус, цаг уур орчны шинжилгээний албаны дарга (Б.Оюунчимэг)-т;

1.6. Аймаг сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөц, малчдын түвшинд бэлтгэх өвс, гар тэжээл, хужир шүүг бэлтгэх тоо хэмжээнд хяналт тавьж, аймгийн аж ахуйн нэгж иргэдийн тариалсан ногоон тэжээл, үр тариаг орон нутагтаа нөөц бүрдүүлэх болон худалдан борлуулах ажлыг зохин байгуулж, өвс хадлан бэлтгэх гадны аймаг сум, аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулан, чанартай, үнэ хямд өвс бэлтгэн нийлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир)-т

1.7. Мал мах борлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг яаралтай зохион байгуулж ажиллахыг “ӨВ-ЭКО-МИЙТ”-ХХКомпанийн захирал (Д.Мөнхтөр)-д

Хоёр.Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг орон нутагт шуурхай авч хэрэгжүүлэх зорилгоор дараахь ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай:

2.1. Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авах;

2.2. Энэ захирамжийн хавсралтаар батлагдсан сумын түвшинд бэлтгэх, аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг чанартай, заасан хэмжээнд бүрдүүлэх;

2.3. Малчин, мал бүхий иргэн байгалийн хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэхэд анхаарч зохион байгуулалтыг ханган ажиллах;

2.4. Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагуудаас зөвшөөрөл авч гэрээний дагуу отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах;

2.5. Отроор өвөлжиж, хаваржих малчин өрхийн судалгаа гаргаж малчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх;

2.7. Отор нүүдлээр явж байгаа малчин өрх тухайн нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагаас тусламж үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай эд материалын хангамжийг нэмэгдүүлэх, уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах.


2.8. Намрын ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх, хүн хүчээр хангаж, хамтран ажиллах.

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 4396 дүгээр захирамжийн гуравдугаар хавсралт

АЙМАГ, СУМЫН ХЭМЖЭЭНД БЭЛТГЭВЭЛ
ЗОХИХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХЭМЖЭЭ

№	Сумын нэр	Нийт аймгийн хэмжээгээр бэлтгэвэл зохих /тн/		
		Өвс	Ногоон тэжээл	Тэжээл
1	Баян-Өндөр	150		50
2	Бүрд	150		50
3	Бат-Өлзий	150		50
4	Баруунбаян-Улаан	150		50
5	Баянгол	150		50
6	Гучин-Ус	150		50
7	Есөнзүйл	150		50
8	Өлзийт	150		50
9	Зүүнбаян-Улаан	150		50
10	Богд	150		50
11	Нарийнтээл	150		50
12	Сант	150		50
13	Тарагт	150		50
14	Төгрөг	150		50
15	Уянга	150		50
16	Хайрхандулаан	150		50
17	Хужирт	150		50
18	Хархорин	150		50
19	Арвайхээр	150		50
20	Аймгийн аюулгүйн нөөцөд /тн/	100	400	150
НИЙТ		2950	400	1100

Аймгийн Засаг даргын 2021 оны...⁰⁸
дугаар сарын 03...-ны өдрийн ^{1/376} дүгээр
захирамжийн дөрөвдүгээр хавсралт



АЙМГИЙН ӨВС, ТЭЖЭЭЛИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦ БЭЛТГЭХ
БАЙГАЛЫН ХАДЛАНГИЙН ТАЛБАЙН ХЭМЖЭЭГ

д/д	Сумын нэр	Хадлан бэлтгэх талбайн хэмжээ /га- аар/
1	Бат-Өлзий	80
2	Уянга	80
3	Зүүнбаян-Улаан	150
4	Хархорин	50
5	Хужирт	50
	Нийт	410

-оОо-